

**Авлигатай тэмцэх эрх зүйн тогтолцоо, хууль тогтоомжийн  
хэрэгжилтэд тулгамдаж буй зарим асуудал**

**The Anti-Corruption Legal Framework and Certain  
Issues in The Implementation of Legislation**

Эрдэнэчулууны Тамир

*Хууль зүйн ухааны магистр (LL.M.).*

*Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хүний эрх, олон улсын  
эрх зүйн секторын Эрдэм шинжилгээний ажилтан*

*Улаанбаатар хот, Монгол Улс*

*Tamir@legalinstitute.mn*



**[Товч утга]**

Энэхүү өгүүлэлд Монгол Улс дахь авлигатай тэмцэх тогтолцоонд тулгамдаж буй авлигын гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдийн дүн шинжилгээ, авлигатай тэмцэх хууль тогтоомжид заасан зөрчил, авлигатай тэмцэх тогтолцоонд итгэх олон нийтийн итгэл, хандлагын асуудлыг судалж үзлээ. Олон улсын болон хөндлөнгийн байгууллагын хийсэн Монгол Улс дахь авлигатай тэмцэх тогтолцооны шинэчлэл, авлигын төсөөллийн индексийн үр дүнг дээрх дурдсан асуудлуудтай холбож, Монгол Улсын үзүүлэлт буурч байгаа шалтгааныг эрэлхийлэхийг оролдов. Авлигын гэмт хэрэгт холбогдсон, мөрдөн шалгах ажиллагаанд яллагдагчаар татагдсан, шүүхээр таслагдсан этгээдүүдийн олонх нь гүйцэтгэх, бага, дунд шатны төрийн албан хаагчид байгаа бол төрийн өндөр албан тушаалтан, улс төрд нөлөө бүхий этгээдүүд шүүхээр таслагдсан тохиолдол цөөн байна. Энэ нь иргэд, олон нийтийн авлигатай тэмцэх тогтолцоонд итгэх итгэлийг бууруулж байна. Авлигын гэмт хэргийн ялын бодлогыг чангалахаас илүүтэй учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хохирлын хэмжээнээс шалтгаалан тохирсон ялыг оногдуулах, төрийн өндөр албан тушаалтан, улс төрд нөлөө бүхий этгээд ял завших боломжийг хязгаарлахад анхаарах нь зүйтэй байна.

**[Түлхүүр үг]**

Авлигатай тэмцэх тогтолцоо, ашиг сонирхлын зөрчил, Авлигын эсрэг хууль, авлигын гэмт хэрэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль.

## I. Оршил

Монгол Улс авлигатай тэмцэх бодлого, эрх зүйн орчин, үйл ажиллагааг тодорхойлсон бие даасан хуулийг хоёр удаа баталж байсан бөгөөд анхны хуулийг 1996 онд Авлигын эсрэг хууль нэртэйгээр 3 бүлэг 18 зүйлтэйгээр баталсан. Үүний дараа 2006 онд тус хуулийг 6 бүлэг, 35 зүйлтэйгээр шинэчлэн баталсан нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Анхдагч хууль нь Монгол Улс дахь авлигатай тэмцэх эрх зүйн орчныг бий болгож, авлигатай тэмцэх чиглэлээр үндэсний стратегитай болох бодит алхам болсон үр дүнтэй. Гэхдээ тухайн цаг үед авлигатай тэмцэх механизм хангалттай түвшинд хөгжиж, бүрэлдээгүй, олон улсын гэрээгээр хүлээсэн “заавал биелүүлэх” шинж чанартай үүргийг бүрэн хүлээгээгүй, авлигын талаарх олон нийтийн ойлголт дутмаг байсан зэрэг бэрхшээл тулгарч байв. Улмаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 тоот тогтоолоор Авлигын эсрэг НҮБ-ын конвенцыг баталж, Монгол Улс 2005 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Авлигын эсрэг НҮБ-ын конвенцыг соёрхон батлав. Тус конвенц нь 8 бүлэг, 71 зүйлтэй бөгөөд авлигын гэмт хэргийг хил дамнасан, олон улсын шинж чанартай тулгамдсан асуудал болохыг тодорхойлж, түүнтэй тэмцэх олон улсын болон үндэстэн улсуудын механизм, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлсэн баримт бичиг болсон юм. Уг конвенц нь *нэгдүгээрт* хөгжиж буй улс орнуудад авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлсэн /*үүнд Монгол Улс ч мөн хамаарна*/, *хоёрдугаарт* авлигын гэмт хэргийг тодорхойлох, оролцогч улсууд дотоодын хууль тогтоомждоо тусгах жишгийг тогтоосон, *гуравдугаарт* авлигатай тэмцэх олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлж, оролцогч улс орнууд харилцан туслалцаа үзүүлэх, хулгайлсан хөрөнгийг буцаах боломжийг бүрдүүлсэн, *дөрөвдүгээрт* оролцогч улс нь авлигатай тэмцэх үндэсний стратегийг хэрэгжүүлж, түүний үр дүнг үнэлэх, дүгнэх орчныг бий болгосон зэрэг ач холбогдолтой.

Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт, уялдаа холбооны талаар өмнө нь хийгдэж байсан судалгааг тоймлон авч үзвэл 1. Олон улсын байгууллаас хийгдэж байсан хөндлөнгийн судалгаа, тайлан, 2. Хууль тогтоох, бодлого боловсруулах, авлигатай тэмцэх байгууллагаас хийгдсэн судалгаа, 3. Авлига, ашиг сонирхлын зөрчлийн чиглэлээр судалгаа хийж буй захиргааны болон эрүүгийн эрх зүйн чиглэлийн судлаачдын судалгаа, бүтээл гэж авч үзэж болно. Тухайлбал ЭЗХАХБ-аас хийсэн “Станбулын Авлигатай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 1-5 дугаар шатны мониторингийн

тайлан”<sup>1</sup>, НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас боловсруулсан Монгол Улс дахь “Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын III, IV бүлгийн хэрэгжилтийн тайлан”<sup>2</sup>, “Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 5-14 болон 51-59 дүгээр зүйлийг Монгол улс хэрхэн хэрэгжүүлж байгааг 2016-2021 оны хүрээнд үнэлсэн тайлан”<sup>3</sup>, Азийн хөгжлийн банк, Канадын засгийн газрын дэмжлэг, санхүүжилттэйгээр хэрэгжсэн Монгол Улсад ардчилсан оролцоотойгоор төрийн албанд сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлэх нь төслийн хүрээнд 2017 онд гүйцэтгэсэн “Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа”<sup>4</sup> гэх мэт олон улсын байгууллагын оролцоо, дэмжлэгтэйгээр хийгдсэн олон судалгаа, тайлан байна. Авлигатай тэмцэх газрын захиалгаар хийсэн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, авлигын эсрэг хууль тогтоомжийн уялдаа холбооны талаар 2023 онд боловсруулсан “Авлигатай тэмцэх газар, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан”<sup>5</sup>, 2018 оноос жил бүр боловсруулж буй “Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал 2018-2023”<sup>6</sup> тайланг жишээлэн дурдаж болно. Эдгээр тайлангуудад Монгол Улс дахь авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилт, олон улсын болон дотоодын үнэлгээний тойм, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн тухайн хугацааны тайлан зэрэг багтжээ. Мөн авлигын эсрэг хууль тогтоомжийг шинэчлэх хүрээнд Улсын Их Хурал, Хууль зүй дотоод хэргийн яамны захиалгаар гүйцэтгэсэн хууль тогтоомжийн судалгаа, авлигатай холбоотой сэдвээр эрх зүйн хөтөлбөр бүхий их дээд сургуулиудад магистрын зэрэг горилсон бүтээлүүд байгааг дурдах нь зүйтэй. Үүнээс ерөнхийлөн үзвэл Монгол Улс дахь авлигын эсрэг хууль тогтоомж, олон улсын гэрээний биелэлтийн үнэлгээ, тайланг олон улсын байгууллага, авлигатай тэмцэх байгууллага, авлигын нөхцөл байдал, нарийвчилсан сэдвээр

<sup>1</sup> OECD, Baseline report of the First, Second, Third, Fourth Fifth round of monitoring of Anti-corruption reforms in Mongolia the Istanbul Anti-corruption Action Plan, (2015-2024).

<sup>2</sup> United Nations, Conference of the States Parties to the United Nations Convention against Corruption, Review of implementation of the United Nations Convention against Corruption. Implementation Review Group Resumed second session, CAC/COSP/IRG/I/1/1/Add.1, (Vienna, 2011).

<sup>3</sup> UNODC, Country Review Report of Mongolia, Review by Singapore and Burkina Faso of the implementation by Mongolia of articles 5-14 and 51-59 of the United Nations Convention against Corruption for the review cycle 2016-2021, (2023).

<sup>4</sup> Азийн сан, “Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа”, 2017.04.17.

<sup>5</sup> Авлигатай тэмцэх газар, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан-2022”, 2023.

<sup>6</sup> Авлигатай тэмцэх газар, “Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал”, 2018-2023.

эрдэмтэн, судлаачид бүтээл туурвиж ирсэн байна.

Монгол Улс нь 2006 онд Авлигын эсрэг хуулийг шинэчлэн баталснаас хойш Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын оролцогч улсын хувьд авлигатай тэмцэх эрх зүйн орчноо олон улсын жишигт нийцүүлж, авлигатай тэмцэх үндэсний стратеги, механизмыг шинэчилж, авлигатай тэмцэх асуудал эрхэлсэн байгууллагын бүрэн эрхийн баталгааг хуульчилсан болно. Гэвч 2025 онд Монгол Улс нь Авлигын төсөөллийн индекс (CPI) -ээр 10 байр ухарч, 182 орноос 124 дүгээрт жагсав. Энэхүү өгүүлэлд Монгол Улс дахь авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигатай тэмцэх үндэсний стратегид тулгамдаж буй зарим асуудал, түүнд нөлөө үзүүлж буй шалтгааныг авч үзэх болно.

## **II. Монгол улс дахь авлигатай тэмцэх эрх зүйн орчин ба тулгамдаж буй асуудал**

### **1. Авлигатай тэмцэх бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт**

Монгол Улс дахь авлигатай тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлж буй гол хууль нь 2006 оны 07 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан Авлигын эсрэг хууль бөгөөд тус хууль нь авлигатай тэмцэх үйл ажиллагаа, авлигатай тэмцэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад чиглэсэн. Өөрөөр хэлбэл тус хууль батлагдсанаар авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллагыг байгуулсан. Тус хуульд 2014 онд нэмэлт оруулснаар авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр / авлигатай тэмцэх үндэсний стратеги/, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний хөтөлбөрийг батлахаар<sup>7</sup> заасан. Улмаар УИХ-ын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталсан. Тус хөтөлбөр нь 2016-2022 оны хугацаанд хэрэгжсэн ба тус хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний үр дүнд уг хөтөлбөрийг 75.8 хувийн хэрэгжилттэй<sup>8</sup> гэж үнэлсэн байна. Мөн тус хөтөлбөрт хууль тогтоомжийн судалгааны батлагдсан арга зүй буюу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан хүчин төгөлдөр үйлчилж

<sup>7</sup> Авлигын эсрэг хууль (2006)-ийн 2<sup>1</sup> дүгээр зүйл, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2006 он, №35.

<sup>8</sup> Авлигатай тэмцэх газар, “Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт-2022”, 2023, 304 дэх тал.

буй хууль тогтоомжид хийгддэг “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний судалгаа”-г хийхэд нийт дэвшүүлсэн 11 зорилтоос 8 нь хөтөлбөрийн 5.1, 5.2-т заасан үр дүнд хүрч, 3 нь зорилтот үйл ажиллагааг явуулж, арга хэмжээ авч ажилласан боловч хөтөлбөрт заасан хүрэх үр дүнд хүрээгүй<sup>9</sup> гэж тус тус үнэлэгдсэн байна.

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн V бүлгийн Зорилго 5-д “Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтоож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр-хувийн хэвшил-иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно.”<sup>10</sup> гэж заасан. Мөн тус баримт бичгийн Зорилт 5.6-д Үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулахаар тусгасан. УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын VI бүлэг Төрийн бүтээмжийн сэргэлтийн 6.5-д “Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгана.”<sup>11</sup> гэж заасан. Өмнөх авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2016-2022 оны хугацаанд хэрэгжиж дууссантай холбоотойгоор УИХ-ын 2023 оны 59 дугаар тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2023-2030”, УИХ-ын 2024 оны 46 дугаар тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г тус тус баталсан. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 49 дүгээр тогтоолоор Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7 дахь заалтад заасан «хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх», Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасан «нийгмийн хэв журмыг сахин хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах» эрхийнхээ хүрээнд 2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлаж, авлигатай тэмцэх 5Ш ажиллагааг хэрэгжүүлсэн. Дээр дурдсан хэлбэрээр Монгол Улс авлигатай тэмцэх урт, дунд, богино хугацааны бодлогоо тодорхойлж, холбогдох хууль тогтоомж

<sup>9</sup> Авлигатай тэмцэх газар, өмнөх эшлэл 6, 353 дахь тал.

<sup>10</sup> Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, V бүлэг, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2020 он, №25.

<sup>11</sup> Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, “Шинэ сэргэлтийн бодлого”, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2022 он, №09.

болон бусад эрх зүйн баримт бичгүүдэд тусгасан байна.

Мөн дээр өгүүлсэн бодлого, стратегийн хүрээнд манай улсад тогтмол авлигатай тэмцэх механизм ажиллаж байна. Монгол Улс дахь авлигатай тэмцэх тогтолцоо нь дараах үйл ажиллагаануудаас бүрдэнэ. Үүнд:

- Авлигатай тэмцэх бодлого, стратегийг тодорхойлох, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, сайжруулах үйл ажиллагаа

*Хэрэгжүүлэгч: УИХ, хуулиар олгосон эрх бүхий байгууллага, бодлого боловсруулагчид*

- Олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

*Хэрэгжүүлэгч: Авлигатай тэмцэх газар, төрийн байгууллагууд*

- Авлига, ашиг сонирхлын зөрчлийг илрүүлэх, хөрөнгө, орлогын мэдүүлгээр дамжуулан хянах ажиллагаа

*Хэрэгжүүлэгч: УИХ-ын Хууль зүйн байнгын хороо, Авлигатай тэмцэх газар*

- Авлигын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, хариуцлага тооцох үйл ажиллагаа

*Хэрэгжүүлэгч: Авлигатай тэмцэх газар, прокурор, шүүх*

- Авлигатай тэмцэх үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах

*Хэрэгжүүлэгч: Улсын Их Хурал*

- Авлигатай тэмцэх үйл ажиллагаа дахь хөндлөнгийн болон олон нийтийн, иргэний нийгмийн хяналтын үйл ажиллагаа

*Хэрэгжүүлэгч: АТГ дэргэдэх Олон нийтийн зөвлөл, иргэний нийгмийн байгууллага, иргэд* зэргээс бүрдэнэ. Авлигын эсрэг хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдлын талаар Авлигатай тэмцэх газрын мэдээллийг УИХ жил бүр мэдээлэх үүрэгтэй. Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Авлигатай тэмцэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, бусад төрийн байгууллагын үйл ажиллагааг Авлигатай тэмцэх газар хяналт тавьж ажиллана. Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөл нь Авлигатай тэмцэх газрын хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон гүйцэтгэх ажил явуулахаас бусад үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй. Авлигатай тэмцэх газраас 2020 оноос эхлүүлэн жил бүрийн авлигын эсрэг хууль тогтоомж, авлигын нөхцөл байдлын тайланг боловсруулж олон нийтэд түгээж эхэлсэн. Гэхдээ өнөөг хүртэл хэрэгжүүлж буй

авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа нь төрийн байгууллагуудад сургалт зохион байгуулах, тараах материал хэвлэх, тэр бүр олны анхаарлыг татахгүй, хандалт муутай контент үйлдвэрлэх хэлбэрээр явагдаж байгаа тул зохих үр дүнг өгөхгүй байна. Нөгөө талаас авлигатай тэмцэх тогтолцоо, үйл ажиллагаа дахь олон нийтийн хяналтын тогтолцоо суларч, иргэний нийгмийн байгууллага, шүгэл үлээгчийн эрх зүйн орчин баталгаажаагүй хэвээр байна. Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд хөндлөнгийн дүгнэлт, зөвлөмж боловсруулахаар хуулиар эрх нь олгогдож, анхлан уг үзэл баримтлалын хүрээнд байгуулагдсан Олон нийтийн зөвлөл нь хуульд заасан үүргээ хэрэгжүүлэлгүй, Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагаатай давхацсан үйл ажиллагаа эрхэлж, зөрчилдөж, тухайн маргааны улмаас шүүхэд хандсан тохиолдол ч гарсан болно. Энэ нь авлигатай тэмцэх тогтолцоонд хөндлөнгийн хяналт хангалтгүй байгааг илтгэж байна. Хууль тогтоогчдын зүгээс авлигатай тэмцэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, ялын бодлогыг чангатгах арга хэмжээг авч байгаа боловч хууль хэрэглээний бодит орчинд ялгаа гарч, улс төрд нөлөө бүхий этгээд, төрийн өндөр албан тушаалтны холбогдсон хэргийн мөрдөн шалгах ажиллагаа удаа дараалан удааширч, зогсож байгаа явдал нь олон нийтийн итгэлийг бууруулж байна.

Авлигын гэмт хэргийн гомдол, мэдээллийг хүлээн авах, хяналт шалгалтын ажиллагааг зохион байгуулах, мөрдөн шалгах, шүүхээр шийдвэрлэх ажиллагааг тасралтгүй хэрэгжиж буй бөгөөд доорх хүснэгтэд авлигын гэмт хэргийн сүүлийн 5 жилийн тойм статистикийг байршууллаа. Авлигын гэмт хэрэг нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар бүлэгт нийт 13 төрлийн гэмт хэргийг хуульчилсан /22.2 дугаар зүйлд заасан Албаны эрх нөлөөг урвуулан ашиглах гэмт хэргийг 2017 онд хүчингүй болгосон/.

*Хүснэгт 1. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан, шүүхээр шийдвэрлэсэн авлигын гэмт хэрэг*

	2021	2022	2023	2024	2025
Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан	1307	1520	1837	1863	1911
Шүүхэд шилжүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлсэн	-	262	325	387	367
Тухайн жилийн эрүүгийн хэргийн үлдэгдэл	-	715	767	825	825
Шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг	160	188	192	216	225

Өмнөх онтой харьцуулсан өсөлтийн хувь	-	+17.5%	+5.4%	+12.5%	4.2%
---------------------------------------	---	--------	-------	--------	------

Дээрх мэдээллээс үзвэл хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй хэргийн тоо сүүлийн 5 жилд 1.3-14.0 хувиар нэмэгдсэн буюу дунджаар 8.75 хувиар өссөн байна. Жил тутамд дунджаар 783 авлигын хэргийн үлдэгдэлтэй байна. Мөн шүүхээр шийдэгдэж буй хэргийн тоо жил тутамд тогтмол өсөж байна. Авлигын гэмт хэргийн 2025 оны статистикийг авч үзвэл мөрдөн шалгах ажиллагаа явуулсан гэмт хэргийн 59.9 хувийг эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, 12.2 хувь нь Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйл буюу хахууль авах гэмт хэрэг, 8.3 хувийг Эрүүгийн хуулийн 22.5 дугаар зүйл буюу Хахууль өгөх, 1.0 хувийг Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйл буюу Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэргүүд<sup>12</sup> тус тус эзэлж байна. Гэмт хэргийн улмаас учруулсан хохирлын хэмжээг Эрүүгийн хуулийн ерөнхий ангид дараах байдлаар тогтоосон нь: их хэмжээний хохирол» гэж тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг; “үлэмж хэмжээний хохирол» гэж арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээг”, бага хэмжээний хохирол” гэж гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс доош хэмжээг<sup>13</sup> ойлгохоор заасан.

Хүснэгт 2. Авлигын гэмт хэрэгт холбогдсон албан тушаалтнуудын ангилал

Албан тушаалтны төрөл	2021	2022	2023	2024	2025
Төрийн захиргааны АТ	149	127	510	290	244
Төрийн улс төрийн АТ	91	56	277	133	116
Төрийн үйлчилгээний АХ	175	84	148	205	193
Төрийн тусгай АТ	145	103	729	241	212
Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан хаагч	-	-	-	106	129
Бусад этгээд	349	814	116	461	475

Харин авлигын гэмт хэрэгт холбогдсон албан тушаалтнуудыг төрийн албаны ангиллаар авч үзвэл 2021 онд авлигын гэмт хэрэгт

<sup>12</sup> Авлигатай тэмцэх газар, “Авлигатай тэмцэх газрын 2025 оны үйл ажиллагааны тайлан”, 2025, 29 дэх тал.

<sup>13</sup> Эрүүгийн хууль (2015)-ийн 2.5 дугаар зүйл, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2016 он, №07.

холбогдон шалгагдсан этгээдийг албан тушаалаар нь ангилбал төрийн захиргааны албан хаагч 149, төрийн улс төрийн албан хаагч 91, төрийн үйлчилгээний албан хаагч 175, төрийн тусгай албан хаагч 145 байгаа бол бусад албан тушаалтан 349<sup>14</sup> байна. Бусад албан тушаалтан гэдэгт төрийн бус байгууллага, хувийн хэвшил, төрийн бусад хэлбэрийн албан тушаалтнууд хамаарч байна. 2022 онд эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдсан этгээд дунд төрийн захиргааны албан хаагч 127, төрийн улс төрийн албан хаагч 56, төрийн үйлчилгээний албан хаагч 84, төрийн тусгай албан хаагч 103, бусад этгээд 814<sup>15</sup> байсан байна. Улмаар 2023 онд авлигын гэмт хэрэгт холбогдсон төрийн захиргааны албан хаагч 510, төрийн улс төрийн албан хаагч 277, төрийн үйлчилгээний албан хаагч 148, төрийн тусгай албан хаагч 729, хувийн хэвшил, ААН, ТББ-ын 116 хүн<sup>16</sup> байна. Тухайн онд авлигын гэмт хэрэгт холбогдсон төрийн захиргааны болон төрийн тусгай албан хаагчдын тоо огцом өссөн ба төрийн үйлчилгээний албан тушаалтанд ч энэ тоо өндөр байна. Харин бусад албан тушаалтны тоо өмнө оны дүнтэй харьцуулахад буурсан байна. Энэхүү өсөлт нь тухайн үеийн мөрдөн шалгах ажиллагааны онцлог мөчлөг таарсан эсвэл улс төрийн сонгуулийн өмнөх жилтэй холбоотой эсэх нь тодорхойгүй. Тийм бол 2024 онд хэрэгт холбогдон шалгагдсан этгээдийн 133 нь төрийн улс төрийн албан хаагч, 290 нь төрийн захиргааны албан хаагч, 241 нь төрийн тусгай албан хаагч, 205 нь төрийн үйлчилгээний албан хаагч, 106 нь төрийн болон орон нутгийг өмчит хуулийн этгээдийн, 461 нь бусад этгээд<sup>17</sup> эзэлж байна. Өнгөрөгч 2025 онд хэрэгт холбогдон шалгагдсан этгээдийн 116 нь төрийн улс төрийн албан хаагч, 244 нь төрийн захиргааны албан хаагч, 212 нь төрийн тусгай албан хаагч, 193 нь төрийн үйлчилгээний албан хаагч, 129 нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан хаагч, 475 нь бусад этгээд<sup>18</sup> эзэлж байна.

Үүнээс үзэхэд жил тутам авлигын гэмт хэрэгт холбогдож буй төрийн албан хаагчдын тоо нэмэгдэж байна. Сүүлийн 5 жилийн тоймыг авч үзэхэд 2025 оныг 2021 онтой харьцуулахад авлигын гэмт хэрэгт холбогдсон төрийн захиргааны албан тушаалтны тоо 38.9 хувиар, төрийн улс төрийн албан хаагч 21.5 хувиар, төрийн үйлчилгээний албан тушаалтан 9.3 хувиар, төрийн тусгай албан хаагч

<sup>14</sup> Авлигатай тэмцэх газар, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан-2021”, 2022, 45 дахь тал.

<sup>15</sup> Авлигатай тэмцэх газар, *өмнөх эшлэл 6*, 353 дахь тал.


<sup>16</sup> Авлигатай тэмцэх газар, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан-2023”, 2024, 53 дахь тал.

<sup>17</sup> Авлигатай тэмцэх газар, “Авлигатай тэмцэх газрын 2024 оны үйл ажиллагааны тайлан”, 2025, 27 дахь тал.

<sup>18</sup> Авлигатай тэмцэх газар, *өмнөх эшлэл 13*, 26 дахь тал.

31.6 хувиар, бусад этгээд 26.5 хувиар тус тус өссөн байна. Эдгээрээс төрийн захиргааны болон, төрийн тусгай албан хаагчдын тоо өндөр буюу 31.6-38.9 хувиар 5 жилийн хугацаанд өссөн байна.

График 1. Авлигын гэмт хэрэгт холбогдсон төрийн албан хаагчид



Эдгээрээс үзэхэд авлигын гэмт хэргийг тодорхойлох, мөрдөн шалгах, шүүхэд шийдвэрлэх эрүүгийн эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн байна. Төрийн захиргааны, төрийн тусгай, төрийн үйлчилгээний албан тушаалтан авлигын гэмт хэрэгт холбогдож, шүүхээр хэрэг нь шийдвэрлэгдсэн тохиолдол цөөнгүй байгаа боловч төрийн өндөр албан тушаалтан авлигын гэмт хэрэгт холбогдох тохиолдолд халдашгүй байдал, бүрэн эрхтэй холбоотой саад, бэрхшээл үүсэж байна. Шүүхээс авлигын гэмт хэрэгт оногдуулж байгаа ял шийтгэлийн төрөл, хохирлын хэмжээ, албан тушаалтны зэрэглэлээс шалтгаалан ялгаатай байна гэж үзэх нийгмийн хардлага хүчтэй байна. Үүнд төрийн өндөр албан тушаалтанд нөлөөлж буй хуулийн ялгаатай байдал, одоог хүртэл парламентаар батлагдаж, эрх зүйн орчин нь бүрэлдээгүй шүгэл үлээгчийн эрх зүйн орчин нөлөө үзүүлж байна. Авлигын гэмт хэрэгт 2024 онд холбогдсон этгээдүүдийн 47.4 хувь нь бага, дунд шатны төрийн албан хаагчид, 34.6 хувь нь бусад этгээд буюу хувийн хэвшил, төрийн бус байгууллага, төрийн үүргийг зарим хэлбэрээр орлон гүйцэтгэж буй албан тушаалтан байна.

Монгол Улс дахь авлигын нөхцөл байдлын талаар 2026 онд Транспэрэнси Интернэйшнл байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжид “Урт хугацаанд хэвисэн төрийн байгууллагын арга барилын улмаас хариуцлага тооцох механизм сул хэвээр байгааг холбогдох үзүүлэлтүүд харуулж байна. Хэдийгээр ардчиллыг хадгалж үлдэх чиглэлээр төрөөс

бодлого, арга хэмжээ авч, ил тод байдлыг нэмэгдүүлэх тодорхой ахиц гарч байгаа боловч ил болсон мэдээлэл болон хариуцлага тооцох явцын хоорондын зөрүү асар их хэвээр байна.”<sup>19</sup> гэсэн байна. Авлигын төсөөллийн индекс үнэлгээ (CPI) -гээр Монгол Улс нь 182 орноос 2025 онд 124 дүгээр жагссан ба 2018 оноос хойш буюу сүүлийн 7 жилийн хугацаанд тогтмол уруудсан үзүүлэлттэй байгаа юм. Үүнд боловсролын зээлийн сан, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, нүүрс тээвэрлэлтийн гэрээ зэргийг ил болгосон нь авлигын төсөөллийн үнэлгээг бууруулахад нөлөө үзүүлсэн. Зөрчлийг ил тод болгохын хэрээр түүний авлигын төсөөллийн үнэлгээ нэмэгдэнэ. Гэхдээ илэрсэн зөрчилд хариуцлага тооцохгүй байгаа, хариуцлага тооцох механизм сул байгаа нь үнэлгээ буурахад нөлөө үзүүлж байна.

Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага буюу OECD-гээс 2024 онд Монгол Улс дахь авлигын эсрэг шинэчлэлийн тав дахь шатны хяналтын үнэлгээний тайланг боловсруулан танилцуулсан. Тус үнэлгээний тайланд 9 үзүүлэлтээр Монгол Улс дахь авлигын нөхцөл байдлыг үнэлсэн ба хамгийн муу үнэлгээг нэгдүгээрт, шүгэл үлээгчийг хамгаалах орчин/0 оноо/, хоёрдугаарт, прокурорын албаны хараат бус байдал /7.3 оноо/ гэсэн үзүүлэлтүүд авсан байна.

*Хүснэгт 3. ЭЗХАХБ, Монгол Улсын үнэлгээ, гүйцэтгэлийн түвшин<sup>20</sup>*

Үзүүлэлт	Үнэлгээний түвшин	Оноо
РА-1 Авлигатай тэмцэх бодлого	Дундаж	47.9 оноо
РА-2 Ашиг сонирхлын зөрчил ба хөрөнгийн ил тод байдал	Дундаж	34.1 оноо
РА-3 Шүгэл үлээгчийг хамгаалах орчин	Муу	0.0 оноо
РА-4 Бизнесийн шударга байдал	Дундаж	31.2 оноо
РА-5 Төрийн худалдан авалтын шударга, ил тод байдал	Сайн	68.3 оноо
РА-6 Шүүхийн бие даасан байдал	Дундаж	49.6 оноо
РА-7 Прокурорын албаны бие даасан байдал	Муу	7.3 оноо
РА-8 Авлигын эсрэг мэргэшсэн байгууллагууд	Дундаж	35.4 оноо

<sup>19</sup> Транспэрэнси Интернэшнл-Монгол, “Авлигын төсөөллийн индекс 2025”, 2025.02.11.

<sup>20</sup> OECD, *Baseline Report of the Fifth round of monitoring of anti-corruption reforms in Mongolia*, at 12 (2024).

РА-9 Авлигын гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах ажиллагаа	Дундаж	39.3 оноо
---	--------	-----------

Үүнээс үзэхэд Монгол Улсад авлигатай тэмцэх тогтолцоо, механизм бүрэлдсэн боловч хууль сахиулах, эрх зүйн орчныг сайжруулахад анхаарах асуудлууд байна. Тухайлбал авлигын гэмт хэрэгт оногдуулж буй ял, хохирлын хэмжээ харилцан уялдаа муутай, бага, дунд шатны төрийн албан хаагчид хохирлын хэмжээнээс үл шалтгааланшүүхээр шийтгэгддэг бол төрийн өндөр албан тушаалтнууд авлигын гэмт хэргээр шүүхээс ял авч буй тохиолдол маш цөөн байна. Энэ нь гэмт хэрэгт холбогдогчдын статистик тоо баримтаас гадна, олон улсын байгууллагаас гаргасан дүгнэлт, зөвлөмжид туссан байна. Иймд Монгол Улс дахь авлигатай тэмцэх бодлого, стратеги, хууль сахиулах ажиллагаа төрийн дунд шатны албан хаагчид руу илүүтэй чиглэж байна. Мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй, үүнээс илүүтэйгээр хяналт тавьж буй байгууллагуудын хараат бус байдлын асуудал хөндөгдөж байна. Мөн авлигын гэмт хэргийн хохирлоос хамаарч бусад гэмт хэрэгтэй төстэй байдлаар зөрчил, гэмт хэрэг гэж ялгах ялгамж байхгүй байгаа тул 100,000-300,000 төгрөгийн хохирол учруулсан, хахууль авсан тохиолдолд түүнийг үлэмж хэмжээний болон их хэмжээний хохирол учруулсантай ижилхэн зүйл ангиар зүйлчилж байна. Зөрчлийн тухай хуульд авлигатай холбоотой зүйл анги байхгүй харин Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зөрчлийн шинжтэй үйлдлийн тодорхойлолт, оногдуулах шийтгэлийг заасан байна. Нөгөө талаас авлигатай тэмцэх тогтолцоонд итгэх олон нийтийн итгэл нь олон улсын байгууллагаас гаргаж буй үнэлгээ, төрийн өндөр албан тушаалтнууд удаа дараалан авлигын гэмт хэрэгт холбогдож буй нөхцөл байдал, тэдгээрт хууль тэгш бус хандаж байна гэх хардлагын улмаас эргэлзээнд хүрч байна.

## **2. Авлигатай тэмцэх тогтолцоонд итгэх иргэд, олон нийтийн хандлагад гарч буй өөрчлөлт**

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын III бүлэгт авлигын гэмт хэрэгт тооцох тодорхой үйлдлийг оролцогч улс нь дотоодын хууль тогтоомждоо тусгасан байхыг заасан. Тэдгээрийг дурдвал 15 дугаар зүйлд аливаа улсын Төрийн албан тушаалтныг хахуульдах, 16 дугаар зүйлд Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах, 17 дугаар зүйлд Төрийн албан тушаалтан эд хөрөнгө завших, ашиглан шамшигдуулах буюу бусад аргаар зориулалтын бусаар зарцуулах, 18 дугаар зүйлд Эрх нөлөөг нь урвуулан ашиглуулах, 19 дүгээр зүйлд Чиг үүргээ урвуулан

ашиглах, 20 дугаар зүйлд Үндэслэлгүйгээр хөрөнгөжих, 20-21 дүгээр зүйлд хувийн хэвшил дэх авлигын гэмт хэрэг, 23 дугаар зүйлд хууль бусаар олсон орлогыг угаах зэрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцох тодорхойлолтыг тусгасан байдаг. Манай улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт тодорхой 12 авлигын гэмт хэргийг заасан./22.2 дугаар зүйл буюу Албаны эрх нөлөөг урвуулан ашиглах гэмт хэргийг хүчингүй болгосон./ Авлигын гэмт хэрэг нь төрийн шударга байдалд халдаж, иргэдийн төрд итгэх итгэлийг бууруулж, нийгмийн нийтлэг үнэт зүйлд халдсан үйлдэл тул гэмт хэрэгт тооцох нь зүйтэй. Онолын хувьд нийгэмд аюултай, хуулиар хориглосон тухайн үйлдэл нь төр, нийгэм, эдийн засаг зэрэг олон салбарт нөлөө үзүүлдэг тул нийгмийн аюулын шинжтэй. Гэхдээ өмнөх бүлэгт өгүүлсэнчлэн манай улсын хууль сахиулах тогтолцоонд нэн ялангуяа төрийн албан тушаалтан авлигын гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд тухайн албан тушаалтны зэрэглэлээс шалтгаалан, төрийн бага, дунд шатны албан хаагчдад хууль илүүтэй хэрэгжиж байгаа бол төрийн өндөр албан тушаалтанд ялгаатай хэлбэрээр хэрэгжиж байгаа тухай олон нийтийн хардлага үүссэн тухайд дурдсан. Энэ нь дараах шалтгаантай гэсэн саналыг дэвшүүлж байна.

*Нэгдүгээрт.* Авлигын гэмт хэрэгт хамааран шалгагдсан, шүүхээр таслагдсан нийт хэргийн ихэнх хувийг эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, хахууль өгөх, хахууль авах гэмт хэрэг эзэлж байна. Эрүүгийн хуульд тухайн гэмт хэргийг хүндрүүлэх нөхцөлийг заасан. Гэвч бага хэмжээний хохирол учруулсан, их хэмжээний хохирол учруулсан этгээдэд оноож буй ял хоорондын зааг, ялгаа бага байна.

*Хоёрдугаарт.* Авлигын гэмт хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн тохиолдлууд дунд эмч, цагдаа, цэцэрлэгийн болон ерөнхий боловсролын сургуулийн багш, нэгжийн шатлалын төрийн захиргааны албан хаагчдын хэрэг олон байгаа бол эсрэгээрээ төрийн өндөр албан тушаалтан, улс төрд нөлөө бүхий этгээд, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компани, улсын үйлдвэрийн газрын удирдах, эрх бүхий албан тушаалтны холбогдсон гэмт хэргийн олонх нь шүүхээр шийдвэрлэгдсэн тохиолдол маш цөөн байна.

*Гуравдугаарт.* Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.2-т заасан албаны эрх нөлөөг урвуулан ашиглах гэмт хэргийг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болгосон. Улмаар 22.1 дүгээр зүйлийн тайлбарт “албан тушаалын байдал гэдэгт албаны эрх нөлөө хамаарна” гэсэн хэсгийг нэмсэн. Гэхдээ өмнө нь 22.2 дугаар зүйлд тусгагдсан “*Нийтийн албан тушаалтан өөртөө, эсхүл өөрийн*

хамаарал бүхий этгээдэд давуу байдал олгуулах зорилгоор өөрөө, эсхүл өөрийн удирдлагад ажилладаг албан тушаалтнаар дамжуулан” гэсэн агуулгын өөрийн удирдлагад ажилладаг албан тушаалтнаар дамжуулан гэсэн хэсэг орхигдсон байна.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан үүргээ шударгаар биелүүлэх хүрээнд Монгол Улс нь дотоодын хууль тогтоомж, эрүүгийн эрх зүйд авлигын гэмт хэргүүдийг хуульчилсан. Авлигын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, гэм буруутай этгээдэд ял, шийтгэл оноох эрх зүйн орчин бүрдсэн. Гэвч төрийн өндөр албан тушаалтан, улс төрд нөлөө бүхий этгээдүүдийн холбогдсон хэргийн шалгах ажиллагаа удаашралтай, ял шийтгэгдсэн тохиолдол цөөн байна. Энэ нь хууль ялгаатай үйлчилж байна гэх олон нийтийн хардлагыг үүсгэж байгаагийн дээр олон улсын байгууллагын болон хөндлөнгийн ажиглалт, дүгнэлтээр хуулийг хэрэгжүүлэх шатанд алдаа, дутагдал гарч байна гэсэн гаргалгаанд хүргэж байна. Нэн ялангуяа олон нийтийг хамарсан жижиг дунд үйлдвэрлэлийн, боловсролын зээлийн сангийн, нүүрсний тээвэрлэлтийн зэрэг томоохон шуугианд ял шийтгэгдсэн, гэм буруу тогтоогдсон этгээд нэн цөөн, байсан ч тэдгээр нь голцуу дунд шатны албан тушаалтнууд байгаа нь авлигатай тэмцэх тогтолцоонд итгэх олон нийтийн итгэлийг бууруулж байна.

### **3. Авлигын гэмт хэрэг ба ашиг сонирхлын зөрчил**

Авлигатай холбогдох зарим харилцаа, ашиг сонирхлын зөрчлийн эрх зүйн зохицуулалтыг тусгасан голлох хууль нь 2012 онд батлагдсан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль юм. Тус хуулиар нийтийн албан тушаалтан болон улс төрд нөлөө бүхий зарим этгээдэд тавигдах 15 хориглолтыг хуульчилсан. Энэ хууль нь нийтийн албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэж болохуйц нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх, хэдийн үүссэн зөрчлийг илрүүлэх, хариуцлага тооцох зохицуулалтыг бий болгосон. Тухайлбал нийтийн албан тушаалтан гэр бүлийн гишүүн болон төрөл, садны хүнээс бусад этгээдээс авсан нэг удаагийн бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны нэг сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн, эсхүл нэг эх сурвалжаас нэг жилийн туршид хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ, хөлс тухайн албан тушаалтны гурван сарын цалинтай тэнцэх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд уг албан тушаалтан энэ тухай эрх бүхий албан тушаалтанд 30 хоногийн дотор бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх үүрэгтэй.<sup>21</sup>

<sup>21</sup> Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (2012)-ийн 16 дугаар зүйл, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2012 он, №08.

Нийтийн албан тушаалтныг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үүсээд буй ашиг сонирхлын зөрчлийг илрүүлэх хүрээнд хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж, АТГ-т мэдүүлдэг.

*Хүснэгт 4. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргасан албан тушаалтны тоо 2020-2025*

	2020	2021	2022	2023	2024
Байгууллагын тоо	117	120	124	127	130
Нийт албан тушаалтан	43,692	47,554	49,680	50,258	48,841
Төрийн захиргааны	12,141	10,904	12,824	12,951	12,441
Төрийн тусгай	13,445	15,872	15,821	11,404	15,202
Улс төрийн	7,741	7,741	7,738	7,765	8,119
Төрийн үйлчилгээний удирдах	5,700	6,838	7,459	11,565	7,341
ТБОНӨХЭ	-	3,074	2,979	3,317	4,447
Бусад албан тушаалтан	4,354	1,814	2,498	2,919	1,087

ХАСХОМ-ыг хүлээн авч, хянаж байгаа явдал нь нийтийн албанд ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэрэг үүсэхээс урьдчилан сэргийлэх, үүссэн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, хариуцлага тооцох гэсэн 3 цогц ажиллагааг хэрэгжүүлдэг. Гэвч жил тутам ХАСХОМ мэдүүлж буй албан тушаалтны тоо нэмэгдэх, бодит бус мэдүүлэг гаргах, хөрөнгөө нуун дарагдуулах зэрэг бэрхшээл тулгамдаж байна.

Авлига нь төр, хувийн хэвшил, нийгэм, эдийн засаг зэрэг олон салбарт хор уршигтай, нийгмийн аюулгүй байдалд сөрөг нөлөө бүхий үйлдлийн хувьд гэмт хэрэгт тооцох нь зүйтэй билээ. Энэ ч утгаараа Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын гишүүн улсын хувьд манай улс нь конвенцод гэмт хэрэгт тооцохоор заасан үйлдлүүдийг эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт тусгасан билээ. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийг үйлдсэн этгээдийн албан тушаалын байдлаас шалтгаалан тухайн гэмт хэргийг хүндрүүлдэг боловч хохирлын хэмжээний их, багаас үл шалтгаалан тус зүйл ангиар шийтгэгдэж байна. Хэдийгээр авлигыг гэмт хэрэгт тооцож, түүний нийгэмд болон бусад учруулсан хохирлыг барагдуулж, хор уршигийг арилгуулах ёстой нь гарцаагүй. Гэхдээ бодит практикт 100,00-300,000 төгрөгийн хахуультай холбогдсон эмч, багш, дунд шатны төрийн албан хаагч, их хэмжээний хохирол учруулсан албан тушаалтан хэдий шийтгэгдэж буй ялын төрөл, хугацааны хувьд ялгаатай боловч ижил төрлийн зүйл ангиар эрүүгийн гэмт хэрэгт ял шийтгэгдэж байгаа

нь олон нийтийн дунд асуулт дагуулж байдаг. Одоо хэрэгжиж буй хууль тогтоомжийн дагуу авлигын гэмт хэрэг гэж байгаа бол авлигын зөрчил гэж байдаггүй. Харин ашиг сонирхлын зөрчил гэж байх ба үүнийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан. Гэхдээ Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд аль алинд нь тус хоёр хуулийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг заасан.

*Хүснэгт 5. Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага*

№	Хууль, хуулийн зүйл	Заалт, хэсэг	Оногдуулах хариуцлага	Хариуцлага оногдуулах субъект
1.	<b>Авлигын эсрэг хууль</b> 6 дугаар зүйл. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа	6.9 дэх хэсэг	- нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох	Шүүгч
2.	<b>Авлигын эсрэг хууль</b> 13 дугаар зүйл. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үндэслэл	13.8.1 дахь заалт	- сануулах	Хуульд тодорхой заагаагүй. Гэвч хянан шалгах эрх нь АТГ-г байдаг. Иймд АТГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу эрх бүхий албан тушаалтан
3.		13.8.2 дахь заалт	- албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах	
4.		13.8.3 дахь заалт	- албан тушаал бууруулах, эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах	
5.		13.8.4 дэх заалт	- албан тушаалаас нь огцруулах буюу ажлаас халах.	
6.		13.9	- албан тушаалын цалингийн	

6.		дэх заалт	хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, уг зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаал бууруулах сахилгын шийтгэл ногдуулна.	
7.	<p><b>Авлигын эсрэг хууль</b> 33 дугаар зүйл. Авлигын эсрэг хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага</p>	33.1.1 дахь заалт	- албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах	эрх бүхий байгууллага, албан тушаалтан
8.		33.1.2 дахь заалт	- албан тушаал бууруулах, хэрэв албан тушаалыг нь бууруулах боломжгүй албан тушаал бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох	
9.		33.1.3 дахь заалт	- төрийн албанаас халах, авлигын зөрчилтэй нөхцөлд гарсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгох	
10.		33.2 дахь хэсэг	- олсон эд хөрөнгө, орлогыг хураах буюу давуу эрхийг хүчингүй болгох	Шүүгч
11.	<p><b>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль</b> 29 дүгээр зүйл. Нийтийн албанд</p>	29.1.1 дахь заалт	- албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох	Шүүгч

12.	нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс	29.1.2 дахь заалт	- хууль бусаар хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ хөлсийг төлүүлж, нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хууль бусаар орсон албан тушаалаас чөлөөлөх	Шүүгч
13.	урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага	29.1.3 дахь заалт	- нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, байгуулсан гэрээ, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, авсан зөвшөөрлийг хүчингүй болгох	
14.		29.1.4 дэх заалт	- албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэгээс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох	
15.		29.2.1 дахь заалт	- сануулах	
16.		29.2.2 дахь заалт	- албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах	эрх бүхий албан тушаалтан
17.		29.2.3 дахь заалт	- албан тушаалыг нь бууруулах	
18.		29.2.4 дэх заалт	- нийтийн албанаас халах	

Авлигын эсрэг хуульд шүүгч хариуцлага оногдуулахаар заасан 2, эрх бүхий албан тушаалтан сахилга, хариуцлага оногдуулахаар заасан 8 зөрчлийг тус тус хуульчилсан байна. Шүүхээс оногдуулж буй хариуцлагад Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан хууль ёсны шаардлага, шийдвэрийг хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан түүний дагуу холбогдох арга хэмжээг аваагүй, албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдэлсэн, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн үйлдэл

хамаарч байна. Эрх бүхий албан тушаалтан хөрөнгө орлогын мэдүүлгийг хянан шалгахтай холбоотой, Авлигын эсрэг хуульд заасан үүргийг биелүүлээгүй, нийтийн албан тушаалтанд хуулиар тусгайлан хориглосон зөрчлийн шинжтэй үйлдлийг хийсэн тохиолдолд хариуцлага оногдуулж байна. Гэвч Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлд заасан хориглох зүйл, Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргийн нэр, тодорхойлолт ижил төстэй бөгөөд аль тохиолдолд гэмт хэрэг, аль тохиолдолд Авлигын эсрэг хуулийг зөрчсөн болох тухайд ялгаа бага байна. Авлигын эсрэг хуульд заасан хориглох зүйлс нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй нөхцөлд хэрэглэхээр заасан боловч энэ төрлийн хууль хэрэглээний судалгаа, шинжилгээ хомс байна.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд зааснаар шүүгч хариуцлага оногдуулахаар заасан 4, эрх бүхий албан тушаалтан хариуцлага оногдуулахаар заасан 4 зөрчлийн шинжтэй үйлдлийг тусгасан байна. Шүүхээс тус хуульд заасан үүргийг биелүүлээгүй эрх бүхий албан тушаалтан, мөн хуулиар тогтоосон хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн этгээд, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих үүргээ биелүүлээгүй, холбогдох баримт бичгийг ирүүлээгүй эрх бүхий албан тушаалтанд шийтгэл оногдуулахаар заажээ. Уг хуулийн 29.1-т Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасныг баримтлахаар заасан тул дээрх үйлдлүүдэд Зөрчлийн шүүх шийтгэл оногдуулахаар ойлгогдож байна. Эрх бүхий албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хожимдуулж гаргасан, хуулийн 10, 14, 17, 18 дугаар зүйл, 20.1, 20.4, 20<sup>1</sup>.2-т заасныг зөрчсөн, хуулийн 9.2-т заасан арга хэмжээг аваагүй, 21.1-д заасан хязгаарлалтад хамаарах этгээдтэй гэрээ, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулсан, зөвшөөрөл олгосон, 23.7-д заасныг зөрчиж илтэд ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийг албан тушаалд томилсон, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг худал мэдүүлсэн, 29.2.2-т заасан хариуцлага хүлээлгэх зөрчлийг удаа дараа гаргасан, 10<sup>1</sup>.1, 10<sup>1</sup>.2, 10<sup>1</sup>.4, 10<sup>1</sup>.5 дахь хэсэг, 11, 12, 15, 16 дугаар зүйлд заасныг зөрчсөн, уг хуулийн 23 дугаар зүйлд заасан хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг гаргаж өгөөгүй, уг хуулийн 29.2.3-т заасан хариуцлага хүлээлгэх зөрчлийг удаа дараа гаргасан тохиолдолд хүснэгтэд заасан хариуцлагыг оногдуулж байна.

Энэ бүгдээс үзэхэд авлигын гэмт хэрэг гэж байгаагаас авлигын зөрчил гэж байхгүй, харин Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчих гэсэн

ойлголт байна. Үүнд шүүхээс болон эрх бүхий албан тушаалтнаас шийтгэл, хариуцлага оногдуулж байна. Гэхдээ дээр өгүүлсэнчлэн их, бага хохирлын хэмжээнээс үл хамааран эрүүгийн гэмт хэргээр зүйлчилж байгаа нь хэдийгээр авлигын гэмт хэрэгт ял оноох, хор уршгийг таслах, цаашид нийгэм дэх энэ төрлийн гэмт хэргийг үйлдэх сэдэлтэй этгээдүүдэд нөлөө үзүүлэх боловч бага, дунд шатны төрийн албан хаагчдад ял хүнддэх, төрийн өндөр албан тушаалтан, улс төрд нөлөө бүхий этгээдүүдэд ял завших боломжийг бий болгож байна. Учруулсан хохирлыг барагдуулалгүйгээр хуульд заасан хариуцлагыг хүлээх нь их хэмжээний хохирол учруулсан зарим этгээдэд ашигтай байх эрсдэлийг үүсгэх талтай. Иймд авлигын гэмт хэрэг дэх ялын бодлогыг чангатгахаас илүүтэй тохирсон ял, шийтгэлийг оноох, түүний эрх зүйн орчныг сайжруулах асуудал чухал байна.

### III. Дүгнэлт

Монгол Улс дахь авлига нь аль нэг салбар, институцийн асуудал гэхээсээ илүүтэй төрийн ихэнх салбар, системд тулгамдаж буй, үндэсний аюулгүй байдалд эрсдэл учруулахуйц хэмжээнд хүрсэн асуудал болсон байна. Авлигатай тэмцэх тогтолцоо, механизм, хууль эрх зүйн орчин, үндэсний стратеги, тэдгээрийн хэрэгжилт, хуульд заасан болон иргэний нийгмийн, хөндлөнгийн үр дүнтэй хяналт зэрэг тогтолцооны ихэнх хэсэгт асуудал бэрхшээлүүд тулгамдаж байна. Эдгээр асуудлаас энэхүү өгүүлэлд зөвхөн авлигатай тэмцэх тогтолцоон дахь зарим асуудал тухайлбал авлигын гэмт хэрэг ба зөрчил хоорондын ялгаа, хууль тогтоомжид хэрхэн туссан тухайд, мөн иргэд олон нийтийн авлигатай тэмцэх тогтолцоонд үзүүлэх итгэлийн асуудлыг авч үзлээ. Улмаар дараах дүгнэлтэд хүрч байна.

1. Монгол Улс авлигатай тэмцэх, ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах тусгайлан хуультай болсноор авлигатай тэмцэх тогтолцоо, механизм бүрэлдэж, энэ чиглэлээр тасралтгүй үйл ажиллагаа явуулж, бодлого, үндэсний стратегийг хэрэгжүүлж байна. Энэ нь тодорхой эерэг үр дүнд хүрч авлигын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, хариуцлага хүлээлгэх, урьдчилан сэргийлэх, авлигыг бууруулахад бодит үр дүнг өгсөн. Гэвч одоог хүртэл бодлогын алдаа гаргасан, эрх зүйн орчныг сайжруулах асуудлууд байсаар байна.

2. Олон улсын байгууллага, хөндлөнгийн үнэлгээгээр Монгол Улсын авлигын үзүүлэлт хангалтгүй үнэлгээ авч байна. Үүнд дараах шалтгаан нөлөөлж байна. *Нэгдүгээрт* шүгэл үлээх, авлигыг мэдээлэх, мэдээлэгчийн нууцлал, аюулгүй байдлыг хангах орчин сул байна. Энэ чиглэлийн эрх зүйн орчин дутмаг, бие даасан хууль эсвэл холбогдох хуулиудад тусаагүй байна. *Хоёрдугаарт* хууль сахиулах байгууллага,

тэр дундаа прокурорын байгууллагын хараат бус байдал хангалтгүй байна. *Гуравдугаарт* авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой мэдээллүүдийг ил болгосноор илэрч буй гэмт хэрэг, зөрчлийн тоо, түүнийг дагасан хардлага, олон нийтийн эргэлзээ нэмэгдсэн байна. Энэ нь олон нийтийн хяналтыг нэмэгдүүлж байгаа боловч, үр дүнтэй хяналтын механизм бүрэлдээгүй байна.

3. Авлигын гэмт хэрэгт холбогдсон, шүүхээр ял шийтгэгдсэн этгээдийн олонх нь гүйцэтгэх, бага, дунд шатны төрийн албан хаагчид болон бусад/хувийн хэвшил/ этгээдүүд байна. Харин төрийн өндөр албан тушаалтан, улс төрд нөлөө бүхий этгээд ял шийтгэгдэж, хариуцлага хүлээсэн тохиолдол цөөн байгаа нь олон нийтийн дунд хардлага үүсгэж, авлигатай тэмцэх тогтолцоонд итгэх итгэлийг сулруулж байна.

4. Авлигын гэмт хэрэгт оноож буй ял, шийтгэлийг чангатгах бодлогыг төрөөс баримталж байна. Гэвч бодит практикт авлигын гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг харгалзах ялгамж хангалтгүй байна. Үүнээс шалтгаалан гүйцэтгэх, бага, дунд шатны төрийн албан хаагч, бусад этгээдэд хүндрүүлсэн ял оноох, их хэмжээний хохирол учруулсан улс төрийн нөлөө бүхий этгээд ял завших боломжийг олгож байна.

5. Авлигын гэмт хэрэг гэж байгаагаас авлигын зөрчил гэж байхгүй, харин Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчих гэсэн ойлголт байна. Гэвч аль тохиолдолд дээрх хуулиудад заасан хориглолтыг эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйгээр зөрчсөн, аль тохиолдолд эрүүгийн гэмт хэрэгт тооцох тухай тодорхойлолт, шалгуур хангалтгүй байна.

#### **IV. Зөвлөмж**

1. Авлигатай тэмцэх ялын бодлогыг чангатгахаас илүүтэй учруулсан хохирлыг барагдуулах, тухайн гэмт хэрэгт тохирсон ял оноох эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарах. Ингэхдээ бага хэмжээний хохирол учруулсан бага, дунд зэрэглэлийн төрийн албан хаагч, бусад этгээдэд оногдуулах хариуцлага болоод төрийн өндөр албан тушаалтан, улс төрд нөлөө бүхий этгээд, их хэмжээний хохирол учруулсан этгээдэд оногдуулах ял, хариуцлагыг нэг зүйл ангиар бус, ялгаатай зүйл ангиар тогтоох.

2. Авлигын гэмт хэрэг гэж байгаагаас авлигын зөрчил гэж байхгүй, харин Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хариуцлагын хууль

хоорондын уялдаа холбоог хангах.

3. Авлигын эсрэг хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг хэрэгжилт, авлигын нөхцөл байдлыг олон нийтээр хэлэлцэх, үнэлэх, шүүмжлэх, сайжруулах цар хүрээг нэмэгдүүлэх, тэр дундаа энэ талаарх иргэний нийгмийн байгууллагын оролцоог сайжруулах чиглэлд анхаарах. Авлигатай тэмцэх бодлогын үр дүн, үнэлгээг зөвхөн явцуу хүрээнд хэлэлцдэг бус өргөн хүрээнд ил тод, шударга, нээлттэй байдлаар хэлэлцдэг болох.

4. Авлигатай тэмцэх тогтолцоонд итгэх иргэд олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд анхаарах, улс төрд нөлөө бүхий этгээд, төрийн өндөр албан тушаалтны хэргийг ил тод, шударга, нээлттэй хэлбэрээр шийдэж буй жишгийг тогтоох.

5. Авлигатай тэмцэх тогтолцоог сайжруулахад олон талын оролцоог нэмэгдүүлэх, иргэд олон нийт, иргэний нийгмийн байгууллага, хууль сахиулах байгууллага, бодлого боловсруулагчид гэсэн уялдаа холбоог сайжруулах.

6. Авлигатай тэмцэх үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж (Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн процессын хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай )-ийн уялдаа холбоог сайжруулах

**[Ном зүй]**

“Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга зам- сайн туршлага”, 2017 он.

Авлигатай тэмцэх газар, “Авлигатай тэмцэх газрын 2018 оны үйл ажиллагааны тайлан”, 2019 он.

Авлигатай тэмцэх газар, “Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2018, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт”, 2020 он.

Авлигатай тэмцэх газар, “Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2019, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (I үе шат)”, 2020 он.

Авлигатай тэмцэх газар, “Авлигатай тэмцэх газрын 2019 оны үйл ажиллагааны тайлан”, 2020 он.

Авлигатай тэмцэх газар, “Авлигатай тэмцэх газрын 2020 оны үйл ажиллагааны тайлан”, 2021 он.

Авлигатай тэмцэх газар, “Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 2020”, 2021 он.

Авлигатай тэмцэх газар, “Авлигатай тэмцэх газрын 2021 оны үйл ажиллагааны тайлан”, 2022 он.

Авлигатай тэмцэх газар, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан-2021”, 2022 он.

Авлигатай тэмцэх газар, “Авлигатай тэмцэх газрын 2022 оны үйл ажиллагааны тайлан”, 2023 он.

Авлигатай тэмцэх газар, “Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт-2022”, 2023 он.

Авлигатай тэмцэх газар, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан-2022”, 2023 он.

Авлигатай тэмцэх газар, “Авлигатай тэмцэх газрын 2023 оны үйл ажиллагааны тайлан”, 2024 он.

Авлигатай тэмцэх газар, “Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2023”, 2024 он.

Авлигатай тэмцэх газар, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан-2023”, 2024 он.

Авлигатай тэмцэх газар, “Авлигатай тэмцэх газрын 2024 оны үйл ажиллагааны тайлан”, 2025 он.

Авлигатай тэмцэх газар, “Авлигатай тэмцэх газрын 2025 оны үйл ажиллагааны тайлан”, 2025 он.

Авлигын эсрэг хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2006 он, №35, 2006 он.

Азийн сан, “Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа”, 2017 он.

Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2024 он, №22, 2024 он.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн тогтоол, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай, 2016 он.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2020 он, №25, 2020 он.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, “Шинэ сэргэлтийн бодлого”, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2022 он, №09, 2021 он.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн тогтоол, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай, 2023-2030, 2023 он.

Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 05 дугаар тогтоол, Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт, 10 дугаар хавсралт, 2024 он.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2012 он, №08, 2012 он.

Нээлттэй нийгэм форум, “Авлигын түвшин тогтоох судалгаа”, 2009 он.

Татварын ерөнхий хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2019 он, №22, 2019 он.

Төрийн албаны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2018 он, №01, 2017 он.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, 2023 он.

Транспэрэнси Интернэшнл-Монгол, “Авлигын төсөөллийн индекс 2025”, 2026 он.

Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2016 он, №07, 2015 он.

Conference of the States Parties to the United Nations Convention against Corruption, “Implementation Review Group Resumed second session”, <https://www.unodc.org/documents/treaties/UNCAC/WorkingGroups/ImplementationReviewGroup/ExecutiveSummaries/V1184854e.pdf>, 2011.

OECD, *Baseline report of the First, Second, Third, Fourth Fifth round of monitoring of Anti-corruption reforms in Mongolia the Istanbul Anti-corruption Action Plan*, 2015-2024.

OECD, *Baseline Report of the Fifth round of monitoring of anti-corruption reforms in Mongolia*, 2024.

Ortrun Merkle, “Anti-Corruption Helpdesk: Mongolia-Overview of corruption and Anti Corruption”, [https://knowledgehub.transparency.org/assets/uploads/kproducts/Country-Profile-Mongolia\\_2018.pdf](https://knowledgehub.transparency.org/assets/uploads/kproducts/Country-Profile-Mongolia_2018.pdf), 2018.

United Nations, *Convention against Corruption*, New York, 2004.

United Nations, Conference of the States Parties to the United Nations

Convention against Corruption, *Review of implementation of the United Nations Convention against Corruption. Implementation Review Group Resumed second session*, CAC/COSP/IRG/I/1/1/Add.1, Vienna, 2011.

United Nations Office on Drug and Crime (UNODC), “Convention Against Corruption- Review Report 2016-2021”, [https://iaac.mn/uploads/users/1279/files/2023\\_10\\_26\\_Mongolia\\_Cycle\\_II\\_Country\\_Report\\_EN.pdf](https://iaac.mn/uploads/users/1279/files/2023_10_26_Mongolia_Cycle_II_Country_Report_EN.pdf), 2023.

UNODC, *Country Review Report of Mongolia, Review by Singapore and Burkina Faso of the implementation by Mongolia of articles 5-14 and 51-59 of the United Nations Convention against Corruption for the review cycle 2016-2021*, 2023.

**[Abstract]**

**The Anti-Corruption Legal Framework and Certain  
Issues in The Implementation of Legislation**

**Tamir Erdenechuluun**

*Master of Laws (LL.M.).*

*Researcher of Human Rights and International  
Law Sector, National Legal Institute of Mongolia  
Ulaanbaatar, Mongolia*

This article examines key challenges within Mongolia's anti-corruption system, focusing on corruption-related offenses, violations of anti-corruption legislation, and public trust and attitudes toward the anti-corruption framework. The study further links these issues with reforms to Mongolia's anti-corruption system undertaken with the involvement of international and independent organizations, as well as with the results of the Corruption Perceptions Index, in an effort to identify the factors contributing to the decline in Mongolia's indicators.

The findings reveal that the majority of individuals implicated in corruption offenses, formally charged during criminal investigations, and ultimately convicted by the courts are executive-level and lower- to mid-level civil servants. By contrast, only a limited number of cases involving high-ranking public officials and politically exposed persons have resulted in judicial convictions. This disparity has undermined citizens' and the general public's trust in the fairness and effectiveness of the anti-corruption system. Therefore, rather than merely tightening sentencing policies for corruption offenses, greater emphasis should be placed on ensuring restitution for the damage caused, imposing proportionate penalties based on the extent of the harm, and restricting opportunities for high-ranking public officials and politically influential individuals to evade criminal liability or punishment.

**[Keywords]**

Anti-Corruption System, Conflict of Interest, Law of Mongolia on Anti-Corruption, Corruption Offenses, Law of Mongolia on the Regulation of Public and Private Interests and Prevention of Conflict of Interest in Public Service.